

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр

1. Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймаг, Бор-Өндөр суманд “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн ажилчдын 230 айлын амины болон нийтийн орон сууцны хотхоны барилга, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зураг, геодез, геологийн судалгаа, төсөв, зөвшөөрлийн зардал хийлгэх гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймаг, Бор-Өндөр суманд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30–ны өдрийн 09 дугаар тогтоолоор тус сумын 2 дугаар баг Тахилгат овооноос төмөр зам хүртэл нутаг дэвсгэрт амины орон сууцны зориулалтаар олгосон 56328 м² газар дээр “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн ажилчдын 230 айлын амины болон нийтийн орон сууцны хотхон барихаар чанар стандартын шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх барилга, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зураг, геодез, геологийн судалгаа, төсөв, зөвшөөрлийг боловсруулна.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 11 дүгээр сарын 12–ны өдрийн 12 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 12 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 12.10 цагт цахимаар нээнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 402 тоот,

И-мейл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-186